

# ХҮҮХДИЙН ОЮУН УХААНЫ ХӨГЖИЛД СЭТГЭЛИЙН ГЭМТЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ СТРЕССЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

*Ж. Нямаа*

*Доктор (Ph. D.), дэд профессор*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*nyamaa12345@must.edu.mn*

**Хураангуй:** Бие махбодийн хүчирхийлэлд өртөж, сэтгэлийн гэмтэл авсан хүүхдүүдийн оюуны үйлдлийн хөгжлийг сэтгэлийн гэмтэл аваагүй хүүхдүүдийн оюуны үйлдлийн хөгжилтэй харьцуулан судлахад сэтгэлийн гэмтэл авсан хүүхдүүдэд юмс үзэгдлийн гол шинжийг олох, гол шинж дээр тулгуурлан оюун дүгнэлт хийх, юмсыг ухаан санаандаа төсөөлж, дүрээр сэтгэх чадвар тус, тус сул хөгжсөн болох нь батлагдав.

**Түлхүүр үгс:** Бие махбодийн хүчирхийлэл, сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стресс, оюун ухаан, оюуны үйлдэл

## УДИРТГАЛ

Өнгөрөгч ХХ зуунд дэлхийн олон улс оронд техникийн шалтгаант осол аваар, дайн байлдаан, хүчирхийлэл, байгалийн гамшиг урьд өмнө тэмдэглэгдэж байгаагүйгээр их болж, олон мянган хүмүүс түүний золиос болжээ. Тухайлбал газар хөдлөлтөөс Италид 80000 хүн (1908), Японд 140000 хүн (1923), Туркэд 30000 хүн (1939), Мароккод 15000 хүн (1960), Чилид 10000 хүн (1960), Перуд 70000 хүн (1970), Хятадад 242000 хүн (1976), Арменид 30000 хүн (1988), Иранд 50000 хүн (1990), Туркэд 17000 хүн (1999) амь насаа алдсан бол Чеченийн Нэгдүгээр дайнд 98000 гаруй цэрэг, Чеченийн Хоёрдугаар дайнд 20000 гаруй цэрэг, Афганы дайнд 750000 гаруй цэрэг, Вьетнамын нутаг дэвсгэрт өрнөсөн дайнд 1100000 гаруй цэрэг алтан амиа алджээ [7, 9].

XXI зууны эхний арван жилийн байдлаар нөхцөл байдал төдийлөн өөрчлөгдсөнгүй. Техникийн болон хүний шалтгаант осол аваар, үндэстэн хоорондын зөрчил, мөргөлдөөн, терроризм, хүчирхийлэл газар авч, түүнд амь насаараа хохирогсод, нэрвэгсэдийн тоо хязгаараа алдав. Үүний зэрэгцээ мэдээллийн технологийн хөгжил, хөдөлмөрийн автоматжилалт, амьдралын хэмнэлийн хурдсал, хотжилт, экологийн асуудал хурцаар тавигдах боллоо.

Үүнтэй уялдан аж үйлдвэржсэн бараг бүхий л орны хүн амын дунд сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын (посттравматический стресс; Posttraumatic Stress) түвшин өсөн нэмэгдээд зогсохгүй энэ үзүүлэлт тогтворжих хандлагатай болов [4, 5]. Тухайлбал Германы эрдэмтдийн

судалгаагаар Европын томоохон хотод амьдарч буй хүмүүсийн ойролцоогоор 52,6 %-д сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын шинж тэмдэгүүд илэрч байгаа нь тогтоогдсон байна [10].

Азийн нэгэн томоохон хот болох Улаанбаатарын хүн амын дунд сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын тархалт өндөр байна. Бидний явуулсан судалгаагаар, 2004 онтой харьцуулбал 2006 онд тус хотын хүн амын дунд сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын үзүүлэлт 12,4 хувиар нэмэгджээ [1].

Энэ бүхэнтэй холбогдуулан сүүлийн жилүүдэд хүний сэтгэцэд үзүүлэх гадны стресс үүсгэгчийн нөлөөллийн асуудал олон шинжлэх ухааны түүний дотор сэтгэл судлалын ухааны тулгамдсан асуудлын нэг болж, судлаачдын анхаарлыг ихээр татах боллоо.

## ҮНДСЭН ХЭСЭГ

Хүний сэтгэцэд нөлөө үзүүлэх өргөн тархсан гадны нэгэн стресс үүсгэгч бол хүчирхийлэл юм. Судлаачдын тооцоогоор, Европт эрэгтэй хүүхдүүдийн 10-аас 72 %, эмэгтэй хүүхдүүдийн 12-оос 56 % нь 16 нас хүртлээ бие махбодийн хүчирхийлэлд өртсөн байдаг бол Азийн янз бүрийн улс орнуудад явуулсан тархвар зүйн судалгаагаар энэ насны хүүхдүүдийн 5-аас 87 % хүртэл нь бие махбодийн хүчирхийлэлд өртсөн байдаг ажээ [6, 10].

Хэдийгээр манай улсад бие махбодийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн тархалтыг тэдний нас, хүйс, эцэг эхийн боловсролын байдал зэрэгтэй холбон нухацтай судалсан байдаг боловч бие махбодийн хүчирхийлэл хүүхдийг хэрхэн сэтгэлийн гэмтэлд оруулдаг, сэтгэлийн гэмтэл хүүхдийн төлөвшил, оюун ухааны хөгжилд ямар нөлөө үзүүлж, сэтгэл зүйн ямар үр дагавар дагуулдаг, сэтгэлийн гэмтэл хүүхдийн хожмын амьдралд ямар ул мөр үлдээдэг талаар судалгааны дорвитой ажил цөөн хийгджээ. Бидэнд мэдэгдэж буй эдгээр цөөн судалгааны ажлуудад асуудалд үйл ажиллагааны хийгээд системт онолын үүднээс хандаагүй, бие махбодийн хүчирхийллээс үүдэлтэй хүүхдийн сэтгэлийн гэмтлийг тодорхойлох сэтгэл зүйн оношлогооны шалгуур, хил хязгаарыг бүрхэгдүүлсэн тал ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ сэтгэлийн гэмтэл бүхий хүүхдүүдийн оюун ухааны хөгжилд биологи, нийгмийн хүчин зүйлсийн үүрэг, харьцааны асуудлын талаар судлаачид санал нэг бус байгаагаас гадна хүүхдийн оюуны хөгжлийн тогтворт байдалд бие махбодийн хүчирхийллийн нөлөөллийн механизмыг тодорхойлоогүй байна. Мөн түүнчлэн бие махбодийн хүчирхийлэлд өртөж, сэтгэлийн гэмтэл авсан хүүхдүүдийн оюун ухааныг хөгжүүлэх технологийн асуудал боловсрогдоогүй байна.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэх нь онолын төдийгүй практикийн ихээхэн ач холбогдолтой. Учир нь хүчирхийллийн дараа үүсч бий болох сэтгэц, зан үйлийн олон тооны асуудлуудыг амжилттай даван туулах эсэх нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн оюун ухааны хөгжлийн түвшин болоод түүнийг хэрхэн удирдан хөтлөх явдлаас олон талаар хамаардаг [2, 3, 8, 12].

Чухам үүнтэй уялдан бид юун түрүүн бие махбодийн хүчирхийлэлд өртөж, сэтгэлийн гэмтэл авсан сургуулийн бага ангийн сурагчдын оюун ухааны хөгжлийн онцлогийг судлахыг зорьсон юм.

Хүүхдийн оюун ухааны хөгжлийн түвшинг IQ (Оюуны илтгэлцүүр, Интеллектуальный коэффициент, Intelligence Quotient)-г тооцоолох замаар түвшинчлэн тогтоож, тэдэнд ялгаварлан хандах уламжлалт хандлагаар бус, харин оюун ухааны хөгжлийн цөм нь оюуны үйлдэл, түүний түвшин, чанар мөн гэсэн сэтгэл судлалын ухааны орчин үеийн үзэл санаа, хандлага дээр тулгуурлан бие махбодийн хүчирхийлэлд өртөж, сэтгэлийн гэмтэл авсан хүүхдүүдийн оюуны үйлдлийг судлах оролдлогыг тус ажилд хийсэн юм.


Бидний судалгааны үндсэн арга нь хүүхдийн оюуны үйлдлүүдийн хөгжил, харьцаа зэргийг нээн илрүүлэх боломжтой өөрийн орны нөхцөлд боловсруулж, сургуулийн бага ангийн түүвэр дээр туршиж үзсэн, монголын сэтгэл зүйчдийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж буй, сэтгэц хэмжилтийн гол, гол шаардлагыг бүрэн хангасан үгэн бус сорил болно.

## **СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

Дэвшүүлсэн зорилгодоо хүрэхийн тулд хүүхдийн түүвэр дээр харьцуулсан судалгаа явуулсан бөгөөд судалгаанд Улаанбаатар хотын ЕБС-ийн гурван сургуулийн 7 насны 424 сурагч хамрагдлаа.

Бид хүүхдүүдийн оюуны үйлдлийн хөгжлийн онцлогийг тогтоохын өмнө тэдний сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын түвшинг хэмжиж үзэв. Тус хэмжилтийг ОХУ-ын ШУА-ийн Сэтгэл судлалын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн “Сэтгэлийн гэмтлийн дараах стрессын сэтгэл зүй ба сэтгэл заслын лаборатори”-ийн эрдэмтэдтэй хамтран боловсруулж, монгол, орос хүүхдүүдийг харьцуулан судлахдаа ашигласан “Хүүхдийн сэтгэлийн гэмтлийн дараах стрессын шинжийг илрүүлэх арга”-аар явуулж, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг үндсэн хоёр хэсэгт хуваалаа. Үүнд: бие махбодийн хүчирхийлэлд өртсөн боловч сэтгэлийн гэмтэл аваагүй хүүхдүүд (хяналтын бүлэг), бие махбодийн хүчирхийлэлд өртөж, сэтгэлийн гэмтэл авсан хүүхдүүд (туршилтын бүлэг) (1-р зургийг үзнэ үү) [1].

Сургуулийн бага ангийн сурагчдын дунд сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын тархсан байдал



1-р зургаас үзэхэд хяналтын бүлэгт нийт судалгаанд хамрагдсан сурагчдын 62,8 %, харин туршилтын бүлэгт тэдний 37,2 % тус тус хамрагджээ. Бидний авч үзэж буй түүврийн хүрээнд сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын тархалт бусад улс оронд явагдсан ижил, төстэй судалгааны үр дүнгүүдтэй бүрэн нийцэж байна. Тухайлбал, Германд хэвлэгдсэн судалгаанд хүн амын дунд сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын үзүүлэлт тэдний биеэр амссан үйл явдлын хэлбэрээс шалтгаалан 27-оос 62 %-ийн хооронд хэлбэлзэж байгааг дурджээ [10].

Судалгаанд хамрагдсан сурагчдын дунд сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын тархалтыг ийнхүү тогтоосны дараа бид хяналтын болон туршилтын бүлгийн сурагчдын оюуны үйлдлийн хөгжлийг дээр тэмдэглэсэн хүүхдийн оюуны үйлдлийн хөгжлийн түвшинг тодорхойлох аргачлалын тусламжтайгаар судлав (1-р хүснэгтийг үзнэ үү).

1-р хүснэгт

Хяналтын болон туршилтын бүлгийн оюуны үйлдлийн дундаж үзүүлэлтүүд

Дэд сорилууд	Хяналтын бүлэг		Туршилтын бүлэг		t	P
	М	δ	М	δ		
Ангилах	6,17	0,26	5,87	1,02	1,35	-
Ерөнхийлөн дүгнэх	8,84	1,08	4,10	0,14	2,18	0,01
Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх	7,56	2,12	4,21	0,69	3,24	0,01
Харьцуулах	5,42	0,10	6,34	0,57	0,16	-

1-р хүснэгтээс үзэхэд хяналтын бүлгийн сурагчид “Ерөнхийлөн дүгнэх” (8,84), “Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” (7,56) дэд сорилын даалгавруудыг нэн амжилттай, харин “Ангилах” (6,17), “Харьцуулах” (5,42) дэд сорилыг дундаж түвшинд гүйцэтгэсэн байна.

Бидний гарган авсан тус үр дүн бага сургуулийн сургалтын онцлогийг тусгаж байж болох юм. Тухайлбал, бага сургуульд сургалт голчлон үзүүлэн таниулах материал дээр тулгуурлан оюуны үйлдлийг идэвхтэй төлөвшүүлэх замаар явагддаг. Үүнтэй уялдан сурагчдын зарим оюуны үйлдлийн хөгжил түргэсч, харин зарим үйлдлийн хөгжил харьцангуй тогтворжиж эхэлсэн байж болох юм. Энэ нь туршигдагчдын оюуны үйлдэл тус бүрийн хазайлтын далайцаар давхар нотлогдож байна.

Хэрэв “Харьцуулах” (0,10), “Ангилах” (0,26) оюуны үйлдлийн хөгжилд тогтворжих хандлага ажиглагдаж байгаа бол харин “Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” (2,12), “Ерөнхийлөн дүгнэх” (1,08) үйлдлийн хазайлтын хувийн үзүүлэлтийн огцом далайц илэрч байна (1-р хүснэгтийг үзнэ үү).

Тус үр дүнг бидний хяналтын бүлэгт явуулсан чанарын дүн шинжилгээ давхар баталж байна. Тухайлбал энэ бүлгийн сурагчид “Ерөнхийлөн дүгнэх” дэд сорилын даалгавруудыг бодит-гадаад шинж тэмдэгээр нь бус, харин тэдний гол шинжээр ерөнхийлөн дүгнэж байв. “Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” дэд сорилын даалгаврыг гүйцэтгэхдээ эдгээр сурагчид зураг тус бүрийг анхааралтай ажиглаж, зураг тус бүрийн үйл явдлуудыг үндэслэн оюун санаандаа тэдний талаар урьдчилсан бүхэл дүрийг бүтээж, түүнийхээ үндсэн дээр зургуудын дэс дарааг тогтоож байлаа.

Иймд судалгааны дээр дурдсан үр дүнг үндэслэн сэтгэлийн гэмтэл аваагүй сурагчдын оюун ухааны хөгжил нь тэдэнд юмс үзэгдлийн гол шинжийг үнэн зөв олох, юмсын гол, гол шинж дээр тулгуурлан оюун дүгнэлт хийх чадвараар тодорхойлогдож байна гэж үзэж болохоор байна.

1-р хүснэгтээс үзвэл туршилтын бүлгийн сурагчид дэд сорилуудыг харилцан адилгүй түвшинд гүйцэтгэжээ. “Ангилах”, “Харьцуулах” дэд сорилын ихэнх даалгавруудыг нэн амжилттай, өндөр түвшинд, харин “Ерөнхийлөн дүгнэх” дэд сорилыг дундаж түвшинд, “Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” сорилыг доогуур түвшинд гүйцэтгэжээ.

Тус үр дүнг туршигдагчдын даалгаврыг гүйцэтгэхдээ гаргасан алдаанаас мөн үзэж болохоор байна. Бие махбодийн хүчирхийлэлд өртөж, сэтгэлийн гэмтэл авсан сурагчдын бараг тэн хагас нь ерөнхийлөн дүгнэх чадвар шаардсан даалгаврыг гүйцэтгэхдээ тэдгээрийг тохиолдлын юмуу гадаад шинж дээр нь тулгуурлан ерөнхийлөн дүгнэж байв. Тэгэхээр, ерөнхийлөн дүгнэх чадварыг илрүүлэхэд чиглэгдсэн сорилын үр дүн судлагдаж буй сурагчдад юмс үзэгдлийн ерөнхий шинжийг олох чадвар сул хөгжсөн болохыг илтгэж байна.

Тус чадвар сул хөгжсөн болох нь “Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” дэд сорилыг гүйцэтгэх явцад сурагчдын авсан доогуур үнэлгээнд бас тусгалаа олов. Хэдийгээр бие махбодийн хүчирхийлэлд өртсөн сурагчид зураг тус бүр дээр юу зурагдсан байгааг сайн мэдэж байсан боловч тэд зураг бүрийн хоорондын холбоог олж, нэгдсэн өгүүлэл зохиож чадахгүй, олон тооны алдаа гаргаж байлаа.

“Ерөнхийлөн дүгнэх”, “Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” сорилуудын үр дүнтэй харьцуулбал “Ангилах”, “Харьцуулах” дэд сорилын даалгавруудыг туршилтын бүлгийн сурагчид амжилттай гүйцэтгэв. “Харьцуулах” дэд сорилыг гүйцэтгэхдээ хүүхдүүд даалгаврын “утга учрыг” түргэн ойлгож, “нуугдсан” зургийг дуртайяа хайж, зөв хариултыг сонгож

байлаа. Даалгаврыг гүйцэтгэхэд нь тохиолдож байсан цорын ганц бэрхшээл бол сурагчид санал болгосон зургуудыг бүрэн төгс задлан шинжлэхгүй, яаран шийдвэр гаргаж байсан явдал болно.

“Ангилах” дэд сорилын даалгавруудыг сурагчид “Харьцуулах” сорилын нэгэн адилаар амжилттай гүйцэтгэв. Тэд юу гүйцэтгэх ёстойг шууд ойлгож, даалгаврыг түргэн биелүүлж эхэлж байв. Гэвч бүх сурагчдад энэ сорилын даалгавар амар хялбар байсангүй. Тэдний зөв “ангилах” чадвар тууштай бус байсан төдийгүй энэ чадвар дэд сорилын зургийн онцлогоос ихээхэн хамаарч байв. Өгөгдсөн зураг дээрх нөхцөл хүүхдүүдийн өдөр тутмын бодит амьдралаас хэдийчинээ хол байх тусам тэдэнд зургийг ангилахад төдийчинээ хүндрэл бэрхшээл тохиолдож байлаа.

Туршилтын бүлгийн хүүхдүүдийн оюуны үйлдлүүдийн үзүүлэлтийг сэтгэлийн гэмтэл аваагүй сурагчдын оюуны үйлдлүүдийн үзүүлэлттэй харьцуулж, туршилтын бүлгийн хүүхдүүдийн оюуны үйлдлийн хөгжлийн өвөрмөц онцлогийг тогтоохыг туршилт судалгааны эцэст оролдсон юм (1-х хүснэгтийг үзнэ үү). Тус харьцуулсан дүн шинжилгээ туршилтын бүлгийн хүүхдүүд хяналтын бүлгийн хүүхдүүдээс оюуны зарим үйлдлийн хөгжлөөрөө ялгаатай болохыг нотоллоо. Хяналтын болон туршилтын бүлгийн хүүхдүүдийн оюуны үйлдлийн дундаж үзүүлэлтүүдийн хооронд “Ерөнхийлөн дүгнэх”, “Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх” оюуны үйлдлүүдээр статистик үнэн магад бүхий ялгаа илрэв (1-р хүснэгтийг үзнэ үү).

Энэхүү илэрсэн ялгаан дээр тулгуурлан бие махбодийн хүчирхийлэлд өртөж, сэтгэлийн гэмтэл авсан хүүхдүүдийн оюун ухааны хөгжил хэд хэдэн өвөрмөц онцлог талтай байна гэж үзэж болохоор байна. Тухайлбал эдгээр сурагчдад юмс, үзэгдлүүдийн гол шинжүүдийг тогтоох, хэд хэдэн гол шинж дээр тулгуурлан оюун дүгнэлт хийх цаашилбал юмс үзэгдлийг ухаан санаандаа урьдчилан төсөөлөх чадвар сул хөгжсөн болох нь нотлогдов.

## **ДҮГНЭЛТ**

Бие махбодийн хүчирхийлэлд өртөж, сэтгэлийн гэмтэл авсан хүүхдүүдэд юмс үзэгдлийн гол шинжийг олох болон юмсын гол шинж дээр тулгуурлан оюун дүгнэлт хийх чадвар сул хөгжсөн нь мөн түүнчлэн үйл явдлыг ухаан санаандаа урьдчилан төсөөлж, ургуулан бодох, дүрээр сэтгэх чадвар сул хөгжсөн нь тэдний сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй байдалтай холбоотой байж болох юм. Тухайлбал хэвийн хэмжээнээс хэтэрсэн бие махбодийн хүчирхийлэл хүүхдүүдийн сэтгэлийн хөдөлгөөний тогтворт байдлыг алдагдуулж, үүний улмаас тэдний сэтгэн бодох чадвар

саарч байж болох юм [2, 3]. Сэтгэлийн гэмтлээс үүдэлтэй стрессын сэтгэл зүйн салбарын нэрт эрдэмтэн, сэтгэл судлалын шинжлэх ухааны доктор (Sc. D.), профессор Н.В. Тарабрина бухимдал, оюун ухааны харилцан холбоог судалж, бухимдал нь оюун ухааны хөгжилд төдийгүй сэтгэцийн бусад үзэгдлийн хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлж байгааг өөрийн явуулсан туршилтаараа тогтоожээ [4]. Иймд хэвшиж тогтсон хэвийн хэмжээнээс хэтэрсэн бие махбодийн хүчирхийлэл нь хүүхдийн оюун ухааны хөгжлийн цөм болсон оюуны үйлдлийн хөгжилд ялангуяа сургалтын үйл ажиллагааны үр дүнд идэвхтэй хөгждөг оюуны үйлдлүүдийн хөгжилд саатуулах нөлөөг үзүүлж байна гэж үзэж болохоор байна.

### **НОМ ЗҮЙ**

[1]. Нямаа Ж. Хүүхдийн сэтгэлийн гэмтлийн дараах стрессын шинжийг илрүүлэх хагас бүтэцжсэн сурвалжлагын аргын хэрэглээний удирдамж. – Улаанбаатар, – "Жаргалан", – 2006, – 54 х.

[2]. Нямаа Ж. Особенности интеллектуального развития у детей, переживших психическую травму // Материалы Международной научно-практической конференции "Личность в развивающемся образовательном пространстве". Часть II. 4-5 мая 2010 года, Ответственный редактор С.И. Галяутдинова. – Уфа, – Россия, – "РИЦ Башкирского государственного университета", – 2010, – С. 59-62.

[3]. Нямаа Ж. Особенности развития интеллектуальных операций у детей младшего школьного возраста, переживших психическую травму // Материалы II Всероссийской научно-практической конференции "Психолого-педагогические и медико-биологические проблемы физической культуры, спорта и туризма". 14-15 мая 2010 года. Ответственный редактор В.Д. Иванов. – Челябинск, – Россия, – "Издательский центр Южно-Уральского государственного университета", – 2010, – С. 69-71.

[4]. Тарабрина Н.В. Основные итоги и перспективные направления исследований посттравматического стресса // Психологический журнал. – 2003, – Т. 24, – № 4, – С. 5-18.

[5]. Breslau N. The Epidemiology of Trauma, PTSD, and Other Posttrauma Disorders // Trauma, Violence, and Abuse. A Review Journal. – 2009, – Vol. 10, – № 3, – July, – PP. 198-210.

[6]. Costello E.J., Erkanli A., Fairbank J.A., Angold A. The Prevalence of Potentially Traumatic Events in Childhood and Adolescence // Journal of Traumatic Stress. – 2002, – Vol. 15, – № 2, – April, – PP. 99-112.

[7]. Fisher G., Riedesser P. Lehrbuch der Psychotraumatologie. 4. Auflage. – München: – "Reinhardt", – 2009, – S. 114-138.

[8]. Hutterer J., Liss M. Cognitive Development, Memory, Trauma, Treatment: An Integration of Psychoanalytic and Behavioral Concepts in Light of Current Neuroscience Research // The Journal of the American Academy of Psychoanalysis and Dynamic Psychiatry. – 2006, – Vol. 34, – № 2, – Summer, – PP. 287-302.

[9]. Nyamaa J. Posttraumatic Stress Disorder in Mongolian Veterans Returning from Iraq // Proceedings International Conference on Posttraumatic Stress Disorder in the Military Veteran. December 21-24, 2007. Edited by S.D. Kumar. – Calcutta, – India, – "Das Gupta", – 2007, – PP. 732-735.

[10]. Posttraumatische Belastungsstörungen. 3. Auflage. Hrsg: A. Maercker. – Heidelberg: – «Springer», – 2009, – S. 33-98.

[11]. *Stadt und Trauma / City and Trauma: Annäherungen-Konzepte-Analysen*. Hrsg: B. Fraist, M. Stromberger. – Würzburg: – “K und N”, – 2004, – S. 12-38.

[12]. Stockton H., Hunt N., Joseph S. *Cognitive Processing, Rumination, and Posttraumatic Growth // Journal of Traumatic Stress*. – 2011, – Vol. 24, – № 1, – February, – PP. 85-92.